



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар A/480

Улаанбаатар хот

“Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.29 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай А/400 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтад аймаг нийслэлийн Засаг дарга гэснийг аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар гэж өөрчлөн найруулж хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүх шатны дарга нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээний газар /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222228

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09
дүгээр сарын 27 - ны өдрийн 1/180
дугаар тушаалын хавсралт

“Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журамд”-д оруулах нэмэлт, өөрчлөлт

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/400 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-д дараах нэмэлт өөрчлөлт оруулсугай.

1.1. Журмын 1.1.дэх заалтыг “Энэхүү удирдамж нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар (цаашид “Эрх бүхий байгууллага” гэх), нарын шийдвэрээр байгуулагдсан комисст (цаашид “Комисс” гэх) хамаарна. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх комисс нь бусад эрх бүхий байгууллагын комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангана” гэж;

1.2. Журмын 1.4.дэх заалтын “Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх комиссын ажлын албаны үүргийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын хэлтэс” гэж;

1.3. Журмын 1.5.дахь заалтыг “Комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бодлого, хэрэгжилт, зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх комисс 9-11, Эм, эмнэлгийн хяналт зохицуулалтын газрын дэргэдэх комисс 9-11, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх комисс 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна” гэж;

1.4. Журмын 1.6.дахь заалтыг Төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх тусгай зөвшөөрлийн комиссын даргаар Төрийн нарийн бичгийн дарга, *Эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын* дэргэдэх тусгай зөвшөөрлийн комиссын даргаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга, Аймаг, нийслэлд ажиллах тусгай зөвшөөрлийн комиссын даргаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга ажиллана” гэж;

1.5. Журмын 1.7.дахь заалтыг “Комиссын бүрэлдэхүүнийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилж чөлөөлнө. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, *Эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын* дэргэдэх тусгай зөвшөөрлийн комиссын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх тусгай зөвшөөрлийн комиссын даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга томилно. Нарийн бичгийн даргыг ажлын алба томилно” гэж;

1.6. Журмын 2.8.дахь заалтыг “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх комисс, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дэргэдэх комисс ажлын 21 хоногт 1 удаа, Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх комисс улиралд 1-2 удаа тус тус хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлаж болно” гэж;

1.7. Журмын 3.1.12. дахь хэсгийн "Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх комиссын ажлын алба нь энэхүү тушаалын гуравдугаар хавсралтад заасан загварын дагуу тусгай зөвшөөрлийн гэрчилгээний маягыг хэвлүүлж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх комиссын ажлын албаны захиалгын дагуу нэгдсэн журмаар олгох ба ажлын алба энэ журмын 8 дугаар зүйлд заасан зааврын дагуу гэрчилгээг хөтөлж, дугаарлах" гэж;

1.8. Журмын 8.2.2. дахь заалтыг Гэрчилгээг олгосон он сар, өдөр гэсэнд комиссын даргын шийдвэр болон шийдвэрийг үндэслэн гаргасан Эрүүл мэндийн сайд, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалын огноог бичнэ" гэж;